

---

# ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

## “СЭНЖ САНТ” ХХК

2012 оны 8-р сар



Энэхүү баримт бичигт багтсан бүх мэдээлэл нь “Сэнж Сант” ХХК-ний өмч бөгөөд тус компаний зөвшөөрөлгүйгээр ашиглах, хэвлэхийг хориглоно.

“Сэнж Сант” ХХК | 1

---

---

Хэвлэсэн огноо	Хэвлэл 1	Өөрчлөлт 1	Өөрчлөлт 2	Өөрчлөлт 3
Тэмдэглэл	Урьдчилсан төсөл 1	Хэвлэл 1		
Огноо	2012 оны 5-р сар	2012 оны 8-р сар		

**ХОЛБОО БАРИХ:**

“Сэнж Сант” ХХК

Захирал Ч.Дэлгэрэхбулаг

Монгол улс

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг

Дамдинсүрэнгийн гудамж

Монполимет цогцолбор

“Сэнж Сант” ХХК

Захирал

Утас. + (976) 91916678

И-мэйл хаяг: [khaliun@monpolymet.mn](mailto:khaliun@monpolymet.mn)

---

## **АГУУЛГА**

1. ТАНИЛЦУУЛГА
2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ
3. ХУУЛЬ ДҮРЭМ, БОДЛОГЫН БҮДҮҮВЧ
4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ
5. “СЭНЖ САНТ” ХХК, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАРИЛЦАА
6. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХӨТӨЛБӨР

---

## **1. ТАНИЛЦУУЛГА**

### **1.1 ОРШИЛ**

Энэхүү баримт бичиг нь Монгол улсын Дорноговь аймгийн Өргөн сум дахь Монцемент цементийн үйлдвэр, ил уурхай болон холбогдох дэд бүтцийн хөгжилд зориулсан “Сэнж Сант” ХХК-ий Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөө юм. Энэ төлөвлөгөө нь төслийн хэрэгжилттэй холбоотойгоор “Сэнж Сант” ХХК-аас авч явуулах оролцогч талуудын үүрэг оролцооны үйл ажиллагааг танилцуулна.

### **1.2 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД**

Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөөний зорилт нь “Сэнж Сант” ХХК-д зориулан оролцогч талуудын үүрэг, олон нийтийн мэдээллийг дэлгэх, зөвлөгөө өгөх үйл явцыг тодорхойлох явдал юм. Энэхүү төлөвлөгөө нь “Сэнж Сант” ХХК-ий үйл ажиллагааг сонирхдог эсвэл түүний нөлөөнд өртөж болох хүмүүс болон оролцогч бүлгүүдтэй харилцахаар компаний зүгээс төлөвлөж байгаа арга замыг тодруулж өгөх юм. Эцсийн зорилго нь мэдээлэл болон нээлттэй харилцан яриаг ил тод, цаг хугацаанд нь хангахад үндэслэн орон нутгийн гол бүлэг, бусад сонирхсон оролцогч талуудтай итгэлцлийн харилцаа холбоог бий болгох явдал билээ. Иймээс энд тодорхойлсон Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөө, үйл явц нь эцсийн зорилгын арга юм. Түүнчлэн үүнд аливаа санаа зовоож байгаа асуудлыг өргөн тавих, компаний үйл ажиллагааны талаархи тайлбар, шүүмжлэл, санал хүсэлт, тэдгээр гомдол/ шүүмжлэлийг хэрхэн зохицуулах тал дээр олон нийт болон оролцогч талуудад зориулсан гомдол заргын механизм багтана.

### **1.3 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү төлөвлөгөө нь зөвхөн Монгол улсын Дорноговь аймгийн Өргөн сум дахь цементийн үйлдвэр, ил уурхай, урт туузан дамжуулагч, төмөр зам, авто зам болон цахилгааны шугамыг багтаасан дэд бүтцийн барилга болон үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлнэ.

Уг төлөвлөгөө нь мэдээллийг дэлгэн мэдээлэхтэй холбоотой олон улсын хамгийн шилдэг практик ажиллагааг анхааран авч үзэх бөгөөд компаниас батлах ерөнхий үүрэг оролцооны зарчмууд болон гол хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдэд хэрэглэгдэх тэдгээр зарчмуудыг товч дүрслэн харуулна.

Энэхүү төлөвлөгөөг тогтмол хянан, шинэчилж байх болно. Хэрвээ оролцогч талуудын үүрэг оролцоотой холбоотойгоор үйл ажиллагаа өөрчлөгдөж эсвэл шинэ үйл ажиллагаа эхэлбэл, уг төлөвлөгөөг хэлэлцүүлэн, төслийн оролцогч талуудтай хуваалцах болно.

### **1.4 АГУУЛГА**

---

Энэхүү баримт бичигт дараахь багтана:

- Бүлэг 2- Төслийн тодорхойлолт ба байгаль орчин, нийгмийн гол асуудлууд
- Бүлэг 3- Олон нийтийн зөвлөгөө хэлэлцүүлэг ба мэдээллийг дэлгэх шаардлагууд
- Бүлэг 4- Оролцогч талууд ба бусад нөлөөнд байгаа талуудын тодорхойлолт
- Бүлэг 5- “Сэнж Сант” ХХК-ийн гүйцэтгэсэн оролцогч талуудын үүрэг оролцооны өмнөх үйл ажиллагааны тойм
- Бүлэг -6 – Оролцогч талын үүрэг оролцооны хөтөлбөр ба үүрэг оролцоо болон нөөц бололцооны аргачлал
- Бүлэг7- Гомдол барагдуулах механизм

## **2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1 КОМПАНИЙ ТАЛААРХИ ЕРӨНХИЙ ТОЙМ**

Монполимет группийн охин компани болох “Сэнж Сант” ХХК нь Өргөн суманд өөрийн эзэмшлийн шохойн чулууны ордыг ашиглан, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд сөрөг нөлөө багатай цементийн үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлж буй компани юм.

Лафарж нь барилгын материал үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч компани бөгөөд зөвлөх гэрээний дагуу уг төслийн техникийн хамтрагч байх болно. Түүнчлэн төслийг амжилттай эхлүүлсний дараагаар үйлдвэрлэлт болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зөвлөхөөр ажиллана. Лафаржийн үзэл баримтлал нь Барилгын материал үйлдвэрлэлийн өнөө үеийн хөгжил чиг хандлага нь хүмүүс, тэдгээрийн хэрэгцээ болон орчинг хүндэтгэн, анхаарал халамжийг бүрдүүлэх ёстой гэж үздэг. Энэхүү үзэл баримтлал нь үйлдвэрлэлийн ноу-хау (Know-how) болон дараах стратегид тусгалаа олдог:

- Гүйцэтгэл
- Үнэлгээг бий болгох
- Ажилтнууд болон орон нутгийн соёлыг хүндэтгэх
- Байгаль орчныг хамгаалах
- Байгалийн баялаг, эрчим хүчийг хамгаалах

### **2.2 ТӨСЛИЙН ОРЧИН**

Төлөвлөж буй төсөл нь

1. ил уурхай
2. урт туузан дамжуулагч
3. цементийн үйлдвэр

---

4. холбогдох дэд бүтэц зэрэг дөрвөн үндсэн хэсгээс бүрдэнэ.

### **2.2.1 Ил уурхай буюу талбай**

Ил уурхайн тусгай зөвшөөрлийн нийт талбай 484 гектар бөгөөд Өргөн сумаас зүүн тийш ойролцоогоор 3 км -г оршино. Шохойн чулууны нөөц нь газрын гадаргууд ил байрлах учир үйл ажиллагаа олборлолтын явцад хөрс хуулалтын ажлын хэмжээг багасгана.



Зураг 1 Ил уурхай/шохойн чулууны илэрц

### **2.2.2 Урт туузан дамжуулагч**

Бутлуураас гарах шохойн чулууг цементийн үйлдвэр хүртэл урт туузан дамжуулагчаар зөөвөрлөнө. Дамжуулагч нь ойролцоогоор 0.84 км байх бөгөөд газрын түвшинтэй нэг түвшинд байрлах хэдий ч газрын гадаргын зүй тогтлоос хамааран зарим хэсэгт өргөгдөнө.

Дамжуулагчийн орчимд өргөгдөх хэсгүүдийн цэгийн мэдээллүүд өгөгдөх болно

### **2.2.3 Цементийн үйлдвэрийн талбай**

Цементийн үйлдвэрийн талбай нь ойролцоогоор 33 гектар байна. Үйлдвэрийн бүтцэд боловсруулах үйлдвэр (бутлуур, тээрэм, хөргөгч, чулуунцрын шатаах зуух гэх мэт багтана), захиргаа, үйлчилгээний төв, засварын газар, гараж, цахилгааны дэд станц, агуулах болон холбогдох дэд бүтэц багтана.

Барилгын ажлын явцад ойролцоогоор 650 гадаад ажилтанг ажиллуулна. Эдгээр ажилчдыг түр орон сууцанд байрлуулна. Гадаад ажилчид болон нутгийн иргэдийн хоорондын харилцааг зохицуулна. Түр орон сууцыг барих талбай тодорхойгүй байгаа хэдий ч Өргөн сумын захиргаатай тохиролцоно гэж ойлгож байна.

Ашиглалтын үед цементийн үйлдвэрт ойролцоогоор 320 хүнийг ажиллуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үйлдвэрийн цех, хэсгүүд жилийн 328 өдөр, 24 цагаар ажиллана. Бүх ажилтнууд үйлдвэрийн талбайгаас хойд зүгт 500 м-г орших орон сууцанд амьдарна.



Зураг 2. Цементийн үйлдвэр

#### **2.2.4 Дэд бүтэц**

Холбогдох дэд бүтэц- 53.3 км урт (110кВ) өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг Сайншандаас үйлдвэрийн талбай хүртэл байгуулна. Энэ шугамын чиглэл нь Өргөн сумыг Сайншанд дахь цахилгааны үндсэн дэд станцтай холбож буй одоо байгаа цахилгааны шугамын (35кВ) дагуу байна. Түүнчлэн ил уурхай руу нэвтрэх зам, 10 км урт ус дамжуулах хоолой болон салбар төмөр замыг байгуулах болно.

### **2.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ ХУРААНГУЙ**

Хөрөнгө оруулалт нь өдөрт 1,867 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий 1 дүгээр шугам, ирээдүйд өдөрт 3,735 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг барих санхүүжилтэнд зориулагдах болно. (Хоёрдугаар үе шатыг энэ үнэлгээний хэсэг болгон дэлгэрэнгүй авч үзээгүй байна). Үйлдвэрийн 1-р шугамыг 2014 онд, 2-р шугамыг 2016 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна.

Үйлдвэр нь өдөрт 1,867 тонн цемент үйлдвэрлэх бөгөөд, жилд 328 хоног ажиллаж 612,376 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай

Хөрөнгө оруулалт нь цементийн үйлдвэр, ил уурхай, урт туузан дамжуулагч болон холбогдох дэд бүтэц зэрэг төслийн дөрвөн гол хэсгүүдийн санхүүжилтэнд зориулагдана.

### **3.ЗОХИЦУУЛАЛТЫН БОЛОН БОДЛОГЫН ХҮРЭЭ**

“Сэнж Сант” ХХК-ийн зүгээс явуулах оролцогч талуудын хэлэлцүүлэг, зөвлөгөөн, мэдээллийг ил тод болгох явдал нь Монголын хууль тогтоомж болон Европын сэргээн босголт хөгжлийн банкны болон гүйцэтгэлийн шаардлагын(10) дагуу олон улсын шилдэг практик үйл ажиллагааны шаардлагад нийцэх болно.

Гүйцэтгэлийн шаардлага 10: Мэдээллийг ил тод болгох болон үүрэг оролцоо юм.

---

Европын сэргээн босголт хөгжлийн банкны байгаль орчин ба нийгмийн бодлогын талаархи мэдээллийг [http://www.ebrd.com/downloads/about/sustainability/ESP PR01\\_Eng.pdf](http://www.ebrd.com/downloads/about/sustainability/ESP_PR01_Eng.pdf) (Англи хэлээр)

<http://www.ebrd.com/downloads/about/sustainability/2008policym.pdf> (Монгол хэлээр)

хуудаснаас харна уу.

Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний журам (1998, шинэчлэн найруулагдсан 2010)

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ /БОНБНУ/ нь байгаль орчны асуудлыг хөгжлийн төлөвлөгөөнд багтаах боломжийг өгдөг. Энэ үйл явц нь холбогдох эрх бүхий байгууллагууд болон оролцогч талуудад байгаль орчинд үзүүлж болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийн талаар мэдээлдэг. 2008 онд БОНБНУ ажлыг гүйцэтгэсэн бөгөөд түүнээс хойш уул уурхайн төлөвлөгөө ба үйл ажиллагаанд зарим төрлийн өөрчлөлтүүд орсон тул бүртгэлтэй, зөвшөөрөлтэй эрх бүхий зөвлөх байгууллагаар төлөвлөж буй Өргөний шохойн чулууг ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг шинэчилсэн байдлаар гүйцэтгэх шаардлагатай байна. Гэсэн хэдий ч тус хуулинд орон нутгийн иргэдийн үзэл бодол, саналыг хэрхэн тусгах тухай тусгайлан заасан заалт, шаардлага байдаггүй.

### **Олон улсын шилдэг практик үйл ажиллагаа**

Олон улсын шилдэг практик үйл ажиллагаа нь төслийн талаарх мэдээллийн нөхцлүүд орон нутгийн бүлэг, иргэдийн эрх, төслийн хэрэгжилтийн явцад оролцогч талуудын үүрэг оролцоо байнга шаардлагатай байдаг гэсэн үндсэн зарчмууд дээр үндэслэгддэг. Энэ төлөвлөгөө нь зөвхөн барилга угсралтын болон ашиглалтын эхний үе шатанд хамаарна. Үйлдвэрийн 2-р шугамыг барих үед төлөвлөгөөг дахин боловсруулна.

Төслүүдийн үр ашигтай үүрэг оролцооны гол үйл ажиллагааны зарчмуудыг доор товч хураангуйлав:

- Оролцогч талуудын хэрэгцээнд нийцсэн, ойлгогдохуйц формат болон хэл дээр ач холбогдол ихтэй мэдээллийг бэлтгэн өгөх
- Зөвлөгөө, хэлэлцүүлгийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах талаар урьдчилан мэдээлэл өгөх
- Оролцогч талуудад мэдээллийг үнэлэн дүгнэхэд хялбар байлгах арга замаар мэдээлэл өгөх
- Орон нутгийн уламжлал, хэл, боломжит хугацаа болон шийдвэр гаргах үйл явцыг хүндэтгэх
- Хоёр талд санал бодол, мэдээллээ харилцан солилцох, тэдгээрийн саналыг сонсох, анхаарах бололцоог өгдөг хоёр талын харилцан яриа



- 
- Нас, эмэгтэй, эрэгтэй, эмзэг болон цөөнх бүлэг зэргийг үзэл бодлын мэдүүлэгт багтаах
  - Сүрдүүлэг, албадлага, хавчилт, эсвэл өдөөн хатгасан үйлдэлгүй үйл ажиллагаа
  - Хүмүүсийн санаа зовниж байгаа зүйлс, санал, гомдолд хариу өгөх тодорхой механизм
  - Төсөл болон хөтөлбөрийн загварт хамтрах, санал хүсэлт хэлэх, оролцогч талуудад эргээд тайлан гаргах

Эдгээр зарчмуудыг “Сэнж Сант” ХХК гаргасан.

### **Оролцогч талын мэдээлэл харилцааг дэмжих**

“Сэнж Сант” ХХК-ийн Төслийн менежментийн хэлтэс, Орон нутгийн харилцаа холбоог зохицуулах менежерээр дамжуулан мэдээлэл харилцааны бүртгэлийг явуулна. Гол мэдээллийг оролцогч талуудад тодорхой харилцан мэдээлэх бөгөөд гол ирэх мэдээллийг (нийтлэг асуултууд, гомдол гэх мэт) авах арга хэмжээний талаарх хураангуйг багтаан явуулах болно.

Энэ мэдээлэл харилцааны журмын нэг хэсэг болгон, “Сэнж Сант” ХХК-ний төслийн менежер эдгээр хэрэгжиж байгаа оролцогч талуудын үүрэг оролцооны үйл ажиллагааг тогтмол бүртгэн, шинэчлэх болно.

## **4. ОРОЛЦОГЧ ТАЛЫГ ТОДОРХОЙЛОХ**

### **4.1 ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ**

#### **Ерөнхий тойм**

Уг баримт бичгийн энэ хэсэг нь сонирхогч талууд, өөрөөр хэлбэл, оролцогч талууд болон орон нутаг, дүүрэг, бүсийн хэмжээнд байгаа бусад талуудыг тодорхойлно. Оролцогч талууд нь эерэг эсвэл сөрөг байдлаар, шууд ба шууд бусаар, төслийн нөлөөнд автаад байгаа өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэхийг хүсдэг хувь хүмүүс болон байгууллага байж болно.

Оролцогч талуудыг дараах бүлгүүдийн хүрээнд тодорхойлдог:

- Олон улсын
- төрийн(төрийн ба бүсийн хэмжээний эрх бүхий байгууллагууд)
- Засгийн газар (аймаг, сум, баг)
- Засгийн газрын бус зөвлөх
- Үйлчилгээ/ханган нийлүүлэгчид
- Үйлчлүүлэгчид
- Хүрээлэнгүүд (их сургууль, эрдэм шижилгээний байгууллагууд)

- 
- Барилгын сектор
  - Иргэдийн төлөөлөгчдийн хурал
  - Улс төрийн намууд
  - Дотоод оролцогч талууд (ажилтнууд)
  - Олон нийтийн бүлгүүд- эмнэлэг, орон нутгийн сургууль, үндэсний өвийн хүрээлэнгийн дэргэдэх
  - Тусгайлан тодорхойлсон компаниуд
  - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Бүх Оролцогч талуудыг хүснэгт 2-д харуулав.

Хэрвээ та жагсаалтанд байхгүй бол, мөн төслийн талаарх мэдээллийг байнга авахыг хүсвэл, доорхи хүнд хандана уу.

**Хадагтай Халиун Цэрэнпил**

**Төслийн туслах ажилтан**

**Мэйл хаяг: [khaliun@monpolymet.mn](mailto:khaliun@monpolymet.mn)**

**Утас: 99220792**

## Хүснэгт 2 Оролцогч талууд ба бусад гол нөлөөнд байгаа талууд

Оролцогч талуудын бүлгүүд	Гол Оролцогч талууд	Тусгай сонирхлын хураангуй
Засгийн газар /үндэсний/	<p>Уул уурхайн яам</p> <p>Байгаль, орчин, ногоон хөгжлийн яам /Стандарт хэмжил зүйн үндэсний агентлаг, Гидрологи, байгал орчин мониторинг, Усны газар/</p> <p>Үйлдвэр Хөдөө аж ахуйн яам</p> <p>Эрүүл мэндийн яам</p> <p>Барилга хот байгуулалтын яам</p> <p>(газар, геодези, картографийн хэрэг эрхлэх газар)</p> <p>Зам тээврийн яам</p> <p>(Төмөр замын хэрэг эрхлэх газар, зам тээврийн газар багтана)</p> <p>Хууль зүйн яам ( Гадаад иргэн харьяатын асуудал эрхлэх газар)</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яам</p> <p>Улсын мэргэжлийн хяналтын газар, үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс</li> <li>▪ Барилга, дэд бүтцийн хяналтын хэлтэс багтана.</li> </ul>	<p>Үндэсний ашигт малтмал ашиглах бодлого ба ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл гаргах</p> <p>Газрын нөхөн сэргээлт</p> <p>Үндэсний байгаль орчин, усны бодлого Мониторинг болон хэрэгжүүлэлтийн хяналт Үүргүүд:</p> <p>Ажилтнууд болон олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах</p> <p>Газартай холбоотой асуудлууд</p> <p>Тээвэртэй холбоотой асуудлууд</p> <p>Гадаад ажилчдын зохицуулалт</p> <p>Соёлын өв хамгаалах</p> <p>Мониторинг болон хэрэгжүүлэлтийн хяналт</p>
<p>Засгийн газар (аймаг, сум, баг)</p> <p>Хууль зүйн болон гүйцэтгэх бүх түвшний салбарууд</p> <p>Хууль зүйн салбар</p> <p>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</p>	<p>Дорноговь аймаг Өргөн сум</p> <p>Аймгийн хяналтын хэлтэс, Өргөн сумын байгаль орчны байцаагч</p> <p>Сэнж баг</p> <p>Сүмийн булаг баг</p>	<p>Байгалийн баялгийн менежментэнд зөвшөөрөл олгох, статистик тайлагнал</p> <p>Олон төрлийн хамгаалалтын бүсийг байгуулах (ус хамгаалах бүс)</p> <p>Байгалийн баялаг ашиглахад жилийн хэрэгцээний хэмжээг тодорхойлох (аймаг, сум)</p> <p>Газар ашиглах, газар эзэмших гэрээг харилцан зөвшилцөх (аймаг, сум)</p>

	Сүмбэр баг Баянмөнх баг	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой менежментийн үйл ажиллагааны хэрэгжилтийг аймаг хянан удирддаг. Сум, аймгийн засаг дарга нар болон хурлууд Байцаагчид хянах, хэрэгжүүлэх  Нийгэм эдийн засгийн хөгжил
Төрийн бус байгууллага/холбоод	Дорноговь аймаг худалдааны танхим/Аж ахуй эрхлэгчдийн холбоо  Албан бус малчдын бүлгүүд (сум, багийн түвшинд) Бэлчээрийн сумын холбоо  Хэрэглэгчдийн бүлгүүд  Багийн хүрээнд бэлчээр хэрэглэгчдийн бүлгүүд  Сумын эрх бүхий байгууллагуудтай хамтран “Сэнж Сант” ХХК-аас тогтоосон байж болох бусад бүлгүүд	Бизнес хөгжлийн боломжууд  Газар эзэмшил: <ul style="list-style-type: none"> <li>▪ Бэлчээр ашиглалт</li> <li>▪ Бэлчээрийн дарамт/нягтрал</li> <li>▪ Усны боломж</li> <li>▪ Бэлчээр болон ус хоорондын малын явах зам , чиглэлийг тусгаарлах</li> </ul>
Үйл ажиллагааны ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид, түүний төлөөлөл  Дотоод оролцогч талууд (ажилтнууд ба үйлдвэрчний эвлэл)	Үндэсний болон орон нутгийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөн болон гэрээлэгч компаниуд  “Улаанбаатар Төмөр Зам” ХК Монголын үндэсний эрчим хүч дамжуулах сүлжээний компани  Тосгоны худаг засвар үйлчилгээний компани: “Чандмань Илч” ХХК Төв оффис: Сайншанд  Үндсэн ажиллах хүч, гэрээт ажилтнууд	Бизнесийн боломжууд, үнэ, төлбөрийн нөхцлүүд  Төмөр зам ашиглах аюулгүй байдлын менежмент  Цахилгааны хангамж, аюулгүйн менежмент Тосгонд цэвэр ус түгээх хэрэгжиж байгаа нөхцлүүд Ур чадварыг хөгжүүлэх, сургалт, эрүүл мэнд, аюулгүй байдал, гадны ажилтнууд гэх мэт
Улс төрийн намууд  Орон нутгийн бүлгүүд  Компаниуд	Аймаг, сумын хурлуудад гол улс төрийн намуудыг төлөөлөх удирдагчид  Сонгогдсон төлөөлөгчид/орон нутгийн удирдагчид  Орон нутгийн оршин суугчид  Тусгай айлууд: <ul style="list-style-type: none"> <li>- Сэнжит худгийн ойролцоо амьдардаг айл</li> <li>- Шувуун хөөвөр булгийн дэргэд амьдрах малчин айлууд</li> </ul> Монголросцветмет (жоншны уурхай) Ялгуун интернешнэл (шохойн жижиг уурхай) Ялгуун Милл (шохойноос замаас үйлдвэрлэх)	Эдийн засгийн ба нийгмийн хөгжил, хөрөнгийн асуудлууд  Байгаль орчны чанар, газар эзэмшил, нөхөн олговор, барилга, замын хөдөлгөөн Ажилын байр, бусад эдийн засгийн үр ашиг Нийгмийн/орон нутгийн хөрөнгө оруулалтын бололцоонууд/санаачлагууд  Бизнесийн боломжууд,

---

	Шүдэт Од (жоншны жижиг уурхай) Чандмань Илч (сумын халаалт, усан хангамжийн компани)	Тэдгээрийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжит нөлөө Хуримтлагдсан нөлөө
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Өргөн сумд өргөн тархсан хэвлэл мэдээлэл: - Өдрийн сонин, Зууны мэдээ сонин  Телевиз радиогийн хэрэгсэл: - Телевиз: Монголын үндэсний телевиз, TV9, MN25, TV5 - Радио станц: FM 101,5 Миний нутаг, Монголын үндэсний радио станц	Уншигч, сонсогч, үзэгчдэд хүргэх орон нутгийн мэдээний зүйлс

---

## **5. “СЭНЖ САНТ” ХХК ОРОЛЦОГЧ ТАЛЫН ХАРИЛЦАА ХОЛБОО**

### **5.1 ОДОО БАЙГАА ОРОЛЦОГЧ ТАЛЫН ҮҮРЭГ ОРОЛЦООНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ**

Орон нутгийн харилцаа холбоо

Компани нь төслийн эхний шатанд тодорхой оролцогч талуудтай зөвлөлдөх, хэлэлцэх зэргийг багтаасан үүрэг оролцооны үйл ажиллагааг явуулсан.

#### **Өмнөх оролцогч талын үүрэг оролцоо**

Тодорхой хэмжээний бэлтгэл ажлууд хийгдээд байгаа бөгөөд үүнд, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, газар эзэмших, эзэмшлийн төлөвлөгөө, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл, ажилчдын түр тосгон, цементийн үйлдвэрийн хашаа зэрэг багтана.

“Сэнж Сант” ХХК нь аймаг, сумын эрх бүхий байгууллагууд болон засгийн газрын яамд, хэлтсүүдтэй хэдийнээ оролцогч талын харилцаа холбоог тогтоогоод байгаа. Ялангуяа, сумын эрх бүхий байгууллагын хүсэлтээр, Өргөн сумын ойролцоо хэд хэдэн үйл ажиллагаа санаачилсан. Жишээ нь: хатуу хог хаягдлын менежментэд туслалцаа үзүүлсэн болно. 2012 оны хавар боловсруулсан нэмэлт БОНБНҮ -ний мэдээлэлд зориулсан урьдчилсан хэрэгжүүлэлтийн нэг хэсэг болгон Орон нутгийн хүн амын төлөөлөгчид болон гол оролцогч талын бүлгүүдтэй хэд хэдэн удаа уулзсан.

ТББ-тай одоогоор ямарваа харилцаа холбоогүй байгаа бөгөөд учир нь тэд орон нутагт идэвхитэй ажилладаггүй байна. Орон нутагт суурилсан байгууллагууд болон холбоодын хувьд, ийм байгууллагуудын гишүүдээр дамжуулан багахан хэмжээний шууд зөвлөгөө хэлэлцүүлэг явуулсан бөгөөд тэд өнөөг хүртэл төслийн хэрэгжилттэй хамаатай өргөн хэмжээний зөвлөгөө, хэлэлцүүлгийн нөхцөлд “Сэнж Сант” ХХК-тай холбоотой байсаар ирсэн.

## **6. ОРОЛЦОГЧ ТАЛЫН ҮҮРЭГ ОРОЛЦООНЫ ХӨТӨЛБӨР**

### **6.1 МЭДЭЭЛЭЛ ИЛ ТОД БОЛГОХ**

Эдгээр гадны мэдээлэл харилцааны зорилтууд нь зорилтот олон нийтэд үйл ажиллагаа, гүйцэтгэл, хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн талаар мэдээлэхийн тулд үүрэг оролцоог тасралтгүй хангах явдал юм.

Орон нутгийн бүлэг нь хэдийгээр тусгайлан зарлаагүй хэдий ч төслийн талаар ерөнхий мэдээлэлтэй байгаа. Орон нутгийн бүлгүүдэд төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэх болно. Жишээ нь, барилгын ажлын хугацаа, тооцоолж байгаа үр дүнгүүд, үйл ажиллагааны үе шатны онцлог шинжүүд гэх мэт.

---

“Сэнж Сант” ХХК олон нийтэд холбогдох мэдээллийг бэлтгэн өгнө. Орон нутгийн болон бүх сонирхсон иргэд дараах баримт бичгийг Компаний вэб хуудаснаас харах боломжтой.

[http://www.monpolymet.com/index.php?option=com\\_content&view=article&id=18&Itemid=18&lang=en](http://www.monpolymet.com/index.php?option=com_content&view=article&id=18&Itemid=18&lang=en)

- Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөө
- Газар эзэмшлийн хүрээ, газар ашиглалт болон эзэмшлийн талаархи гол зарчмууд
- Төслийн техникийн бус тодорхойлолт
- Байгаль орчин, нийгмийн үнэлгээний мэдээллийн тайлан

Түүнчлэн бүх мэдээллийг хэвэлмэл хувилбараар Өргөн сумын Сүмбэр, Сэнж баг, Сайншанд хот дахь Аймгийн Засаг Даргын Тамгын газарт өгөх боломжтой.

Мөн доорх хаягуудаар мэдээллийг авах боломжтой:

**“Сэнж Сант” ХХК, Өргөн сумын оффис**

Талбайн менежер: Лунтангийн БОЛДБАЯР

И-мэйл хаяг: boldbayar@monpolymet.mn

Tel: +(976) 99905725

Веб хуудас: www.monpolymet.com

**“Сэнж Сант” ХХК, Улаанбаатар оффис**

Монгол улс

Улаанбаатар хот

Олимпийн гудамж – 14

Тэнгэрийн цаг төв,

Phone. + (976) 11 311 633

Холбогдох хүн:

Цэрэнпилийн ХАЛИУН

Төслийн туслах ажилтан

Мэйл хаяг: khaliun@monpolymet.mn

Утас: 99220792

**Сайншанд:**

Сайншанд сумын Засаг Даргын Тамгын Газар

Засаг дарга: Б.Батбаяр

Факс: 01522-22440

Гар утас: 93019955

Монгол улс, Дорноговь аймаг

---

**Өргөн сум:**

Өргөн сумын Засаг Даргын Тамгын Газар

Засаг дарга С.Пүрэвхүү

Факс: 025248-4052

Гар утас: 99041769

Монгол улс, Дорноговь аймаг

Эдгээр бичиг баримтуудыг төсөл хэрэгжих хугацааны туршид олон нийтэд ил тод байлгана. Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөөг тогтмол шинэчилнэ.

Мэдээллийн төрлүүд болон “Сэнж Сант” ХХК-ийн авч явуулах мэдээлэл харилцааны арга хэрэгслүүдийг хүснэгт 3-т (Оролцогч талын үүрэг оролцооны хөтөлбөр) товч хураангуйлав.

## **6.2 ИРЭЭДҮЙН ХӨТӨЛБӨРҮҮД**

Төслийн менежер нь мэдээлэл харилцааны үйл ажиллагааг хариуцна. Барилгын ажил эхэлмэгц, орон нутгийн харилцаа холбоо, оролцогч талын үүрэг оролцооны хэрэгжиж байгаа хөтөлбөрийг удирдан чиглүүлэх үүрэгтэй хүнийг томилох болно. Хэрвээ нэмэлт үүрэг, хариуцлагуудыг эцэслэн шийдвэрлэвэл, Оролцогч талуудын үүрэг оролцооны төлөвлөгөөг шинэчлэх болно.

Хэлтэс нь ирээдүйн төслүүдтэй холбоотой аливаа тайлбар, шүүмжлэл, санал хүсэлтийг шалган, баримтжуулна. Бүх мэдээлэл харилцааг санал хүсэлт, ашиг сонирхлыг хангах үүднээс өөрчөлт хийх боломжид зориулан хянан магадлах бөгөөд үр дүнг харилцагчид мэдээлнэ.

### *Орон нутгийн зөвлөх хороо*

Орон нутгийн бүлгүүд шаардлагатай гэж үзвэл Зөвлөх хороог Өргөн сумын орон нутгийн гол бүлэгтэй хамтран байгуулах болно. Үүнд тосгоны дарга, албан бус орон нутгийн малчдын төлөөлөгчид, бүсийн эрх бүхий байгууллага болон орон нутгийн сургуулийн төлөөлөгчийн бүлэгт орон нутгийн гол төлөөлөгчид багтана. Орон нутгийн бизнесийн хүмүүс, болон залуучууд бусад бүлгүүдийг оролцохыг урина. Бүлэг нь үүсэн бий болж байгаа асуудлуудын талаар хэлэлцэх, төлөвлөсөн оролцогч талын үүрэг оролцооны үйл ажиллагааны талаар зөвлөлдөх, орон нутгаас гарах шаардлага, санаа зовоосон асуудлын талаар төслийн багт санал бодлоо хэлэх асуудлыг зохицуулна.

Тогтмол шинэчлэгдэн, хянан магадлагдаж байх үүрэг оролцооны цаашдын хөтөлбөрийг доор танилцуулав.





Хүснэгт 3 Оролцогч талын үүрэг оролцооны хөтөлбөр

Үйл ажиллагаа	Мэдээллийн төрөл	Уулзалт болох байрлал, огноо/мэдээлэл, харилцааны хэлбэрүүд	Оролцогч талын бүлгүүд
<b>БАРИЛГЫН ӨМНӨХ ҮЕ ШАТ</b>			
Нэмэлт мэдээллийн тайлан	ТЕХНИКИЙН БУС ТОДОРХОЙЛОЛТ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нэмэлт мэдээлэл Барилга угсралт болон үйл ажиллагааны явцад ашиглахыг зогсоох, сөрөг нөлөөллийг бууруулах, зайлсхийх арга хэмжээ авах.	Орон нутгийн хэвлэл мэдээлэл, радиоогоор дамжуулан нэмэлт мэдээлэл болон олон нийтийн хэлэлцүүлэгт зориулан төлөвлөгөөг сурталчлах  Зар сурталчилгаа дараахь мэдээллийн хэрэгслээр хийгдэнэ. - Өдрийн сонин, Зууны мэдээ - Радио станц: FM101.5 Миний нутаг	Засгийн газар ТББ Орон нутгийн бүлгүүд Боломжит үйлчлүүлэгчид Олон нийт
Нэмэлт мэдээллийн тайлан	ТЕХНИКИЙН БУС ТОДОРХОЙЛОЛТ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нэмэлт мэдээлэл	Олон нийтийн хэлэлцүүлгийн уулзалт, Баг тус бүр дээр нээлттэй цуглаан, санал хүсэлтийн дэвтэр нээлттэй байна. Мэдээлснээс хойш 30 хоногт дээрх үйл ажиллагааг орон нутгийн иргэд тухайн нутагтаа байх цагт(баяр наадмын үеэр) явуулна.  Хэлэлцүүлгийн урилгыг бүх тодорхойлсон төслийн талбайг ашиглаж байгаа малчид ба	Орон нутгийн иргэд Олон нийтийн бүлгүүд Төрийн эрх бүхий байгууллагууд Малчдын төлөөлөл

		<p>оролцогч талуудад өгнө:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэвлэлийн зар сурталчилгаа, орон нутгийн хэвлэл мэдээлийн хэрэгсэл телевиз, радиогоор олон нийтийн хэлэлцүүлгийн уулзалт болох газар, цаг, огноог зарлах</li> <li>• Олон нийтийн зарын самбар, дэлгүүр, орон нутгийн байгууллагууд дээр зар тавих</li> <li>• Уулзалтын огноо, цаг, хамрах хүрээний талаар дэлгэрэнгүй өгсөн мэдээллийг товхимолоор дамжуулан орон нутгийн бизнесийн бүлгүүд, оршин суугчдад нээлттэй цуглаан, тээврийн нөхцлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хүргэх</li> <li>• Өргөн, Сайншанд хотод олон нийтийн зарын самбарууд дээр албан ёсны зарлал мэдэгдэл тавих</li> <li>• Уулзалт болохоос 3-н долоо хоногийн өмнө Өргөн суманд байрлах малчдын бүлгийн ахлагчид мэдээлэх</li> </ul>	
--	--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

		<ul style="list-style-type: none"> <li>Төслийн боломжит нөлөөлөлтэй холбоотой талбайд айлчлах, шинэ малчин айлуудтай уулзах, бүсийн оршин суугчидтай уулзалт болон нээлттэй цуглаан хийх, талаар 3-н долоо хоногийн өмнө мэдээлж мэдээллийн хүрээ, тээврийн нөхцлийн талаар шууд хэлэлцэж болно. Үүнд үнэгүй тээвэрлэлт багтах ба хэрвээ шаардлагатай бол захиалга өгөх харилцах мэдээллийг өгөх. Айлчлалд төслийн ашиглах бүх талбай, болон хойд уст давхаргын бүс, орчин тойрны булаг, худаг, түр зуурын усан эх үүсвэр гэх зэрэг газар багтана. Талбайд айлчлах хүмүүсийн бүрэлдэхүүнд дамжуулах шугамын маршрутын орчмын газар ашиглагчид багтах ёстой.</li> </ul> <p>Зар сурталчилгаанд алслагдсан байгаа хүмүүсийг оролцуулахын тулд Сэнж Сант –аас хангах тусгай</p>	
--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

		<p>тээвэрлэлтийн талаархи мэдээлэл багтана. Энэ нь төслийг сонирхож байгаа малчид байна.</p> <p>Уулзалт цуглааны бүх бүртгэлийг хийх бөгөөд, тавьсан асуулт, шүүмжлэл, тайлбарын хариултыг эргэн тайлагнана.</p>	
Барилгын өмнөх ерөнхий төлөвлөлт ба барилгын өмнөх талбайн бэлтгэл ажил	<p>туслах үйл ажиллагаануудыг багтаасан Талбайн бэлтгэл ажил болон барилгын нийт хуваарь, оролцогч талын сонирхлын гол үе шатууд ба боломжит үе шатууд, үүнд усан хангамжийн системийн гүйцэтгэл, төмөр замын холболт, тосгоны худгийг барих, байгуулах, / үйл ажиллагааны түр сууринг байгуулах зэрэг багтана.</p>	<p>Олон нийтийн зарын самбар дээр зар тавих, дэлгүүр, орон нутгийн албан оффисууд дээр</p> <p>Товхимол номоор болон нээлттэй цуглаанаар дамжуулан орон нутгийн бизнесийн бүлэг, оршин суугчдад хүргэх мэдээлэл, Олон нийтийн зарын самбар,</p> <p>Хэвлэл мэдээллийн зар сурталчилгаа, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, радио.</p> <p>Орон нутгийн харилцаа холбооны бүлгүүд, сар тутмын уулзалт.</p> <p>Зөвлөх хороог Сэнж баг дээр барилгаас өмнө байгуулна.</p> <p>Орон нутгийн менежментийн бодлогыг боловсруулан, SSL болон хороо зөвшөөрнө.</p> <p>Газар ашиглалтын ерөнхий хүрээн дэх бүрэн үүрэг амлалтуудын хэрэгжилт. Үүнд</p>	<p>Орон нутгийн бүлэг</p> <p>Олон нийтийн бүлгүүд</p> <p>Олон нийт</p> <p>ТББ</p>

		газрыг ашиглах эсвэл эзэмшихээс өмнө газрын талбайн тусгай ашиглагчийг тогтоох явдал багтана. Үе шат тус бүр дээр эдгээр ашиглагчдын тусгай хэрэгцээг тодорхойлох болно. Эдгээр газар ашиглагчид болон тэдгээрийн шаардлагуудад нөлөөлөх аливаа боломж байвал, нөлөөллийг бүрэн үнэлэх бөгөөд ашиглагчид аливаа хохирол алдагдал учруулахгүйн тулд хохирол барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	
Малчидтай тусгайлан хэлэлцэх: Нэмэлт мэдээллийн тайлан	ТЕХНИКИЙН БУС ТОДОРХОЙЛОЛТ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нэмэлт мэдээлэл  Төслөөс усны нөөцийг ашиглах, газар эзэмшил, ашиглалтын талаархи мэдээлэл	Баг тус бүрт хийгдэх бүлгийн хурлуудад анхаарах. Малчдад онцгой анхаарал хандуулах	Малчдад анхаарах
Өргөн сумын эмэгтэйчүүдтэй тусгайлан хэлэлцэх: төслийн бүрэлдэхүүн хэсгүүд болон боломжит потенциалын талаархи хэлэлцүүлэг	Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн талаархи мэдээлэл, ялангуяа, барилгын гадаад ажилчдыг ажиллуулж байгаа талаар, ажил эрхлэлтийн боломжууд багтана.	Өргөн сумд явагдах бүлгийн хурлуудад анхаарах. Залуу хүмүүст онцгой анхаарал хандуулах	Залуу хүмүүст тусгайлан анхаарах
Тосгоны шинэ худгийн гүйцэтгэлийн талаар зөвлөлдөх, хэлэлцэх	Усан хангамжийн талаарх мэдээллийг, Байгаль, орчин, ногоон хөгжлийн яаманд өгөх (Чандмань Илч ХХК-аас авах	Тосгоны шинэ худгийг ашиглахаас өмнө бичгэн мэдээлэл болон зөвшөөрөл  Худаг засварлах хариуцлагын	Байгаль, орчин, ногоон хөгжлийн яам Байгаль, орчин, ногоон хөгжлийн яам

	<p>боломжтой) үүнд:  -Ундарга, шаардлага хангасан түвшингээр тогтвортой хангамжийг харуулах тооцоолол  - Эрүүл мэндийн яам болон Монголын стандартын дагуу уух усны зориулалтын баталгаа ба усны чанар  - усны чанарын стандартад хүрэхэд шаардлагатай ус цэвэршүүлэх байгууламж багтана.</p> <p>Худгийн засварын үүрэг хариуцлагын талаархи бичгэн гэрээ</p>	талаархи бичгээр үйлдсэн гэрээ	Чандмань Илч ХХК Төв оффис: Сайншанд
Одоогийн Сэнжит Худаг худгийн ашиглалтанд нөлөөлөх тосгоны шинэ худгийн нөлөөллийн талаархи хэлэлцүүлэг	<p>Одоогийн Сэнжит худагт нөлөөлөх тосгоны төлөвлөсөн шинэ худгийн нөлөө.  Тосгоны шинэ худгийн гүйцэтгэлийн хуваарь, болон байнгын хэрэгцээ.  Ажил эхлэх боломжийн талаархи хэлэлцүүлэг, жишээ нь, Монцемент төсөлд жолоочоор ажиллах</p>	Ус шавхалтын станцын ойролцоо амьдрах хүмүүст шууд зөвлөгөө өгнө.	Ил уурхайн хажууд байгаа Ус шавхалтын станцын ойролцоо гэрт амьдрах оршин суугчид
10 км урттай ус дамжуулах хоолой суурилуулах талаар малчидтай хийх хэлэлцүүлэг, Усны шинж чанарт нөлөөлөх түр зуурын нөлөөлөл	<p>Талбайг ашиглаж байгаа малчид болон Өргөн сумын малчдын бүлэгтэй хийх хэлэлцүүлэг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын ажлын хуваарь</li> <li>- түр хугацаанд талбай руу нэвтрэх, хөндлөн гарахыг хязгаарлах</li> </ul>	Барилгын ажил эхлэхээс өмнө газар эзэмшиж буй малчдын талаар үнэлэлт дүгнэлт өгнө.	Ус дамжуулах шугамын барилгын ажлыг эхлүүлэх тодорхой хугацаанд тус бүс нутагт байгаа малчид

	<ul style="list-style-type: none"> <li>- барилгын явцад гарах гадаргуугийн усны урсгалын боломжит өөрчлөлт</li> <li>- хэрвээ шаардлагатай бол усыг гадаргуугийн усны хуримтлалын талбай руу насосоор шахах</li> </ul>		
Ил уурхай болон цементийн үйдвэрийн талбайн археологийн үнэлгээ	Монголын шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэнтэй хэлэлцэн зөвлөлдөх	Талбайн орчимд археологийн эд зүйлс байж болох дэлгэрэнгүй үнэлгээг үе шаттайгаар гаргаж хэлэлцэх	Засгийн газрын байгууллага: Монголын шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэн
Барилгын ажилчдын түр тосгон /кемп/ байгуулах	Барилгын ажлын хуваарь Тухайн талбайд түр хугацаагаар оршин суух ажиллах хүчний дэлгэрэнгүй мэдээлэл Түр тосгонд байрлах ажилчдын ёс зүйн дэлгэрэнгүй дүрэм, үүнд түр тосгоны бие даасан байдал, түр тосгоныг хаалттай байх үеийн статус болон соёлын талаархи мэдээлэл багтана. Барилгын үе шатанд орон нутгийн ажил эрхлэлтийн боломжуудын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл	Өргөн сумын томилсон төлөөлөгч/орон нутгийн удирдагчтай зөвлөлдөн Өргөн сумынхантай шууд хэлэлцэн зөвлөлдөх  Сэнж багт барилгын ажлаас өмнө байгуулагдах Зөвлөх хороо нь ажилчдыг байрлуулах, зохицуулалт болон Өргөн сум руу нэвтрэн орохыг хязгаарлах, соёлын үйл ажиллагаа болон орон нутгийн худалдаагаар дамжуулан аливаа төлөвлөсөн харилцааг зохицуулах талаар зөвлөлдөнө.  Зөвлөгөө, хэлэлцүүлэгтэй уялдуулан ёс зүйн дүрмийг дахин боловсруулж болно.	Өргөн сумын орон нутгийн бүлэг –нийт иргэд
Шувуун Хөөвөр булгийн ашиглалт	Шувуун Хөөвөр булагт нөлөөлөх боломжит нөлөөллийн	Төслийн үйл ажиллагааг явуулахаас өмнө, малчдын	Малчдын бүлгүүд: Шувуун хөөвөр булгаас 5 км-д



	талаархи мэдээлэл	<p>бүлэгтэй уулзах, хэлэлцэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- булагт нөлөөлөх боломжит нөлөөлөл</li> <li>- цаг хугацаа</li> <li>- Усны нөөцийг ашиглахтай холбоотой боломжит бусад эх үүсвэрүүд</li> <li>- ашиглагдаж болох булгийн эх үүсвэр</li> </ul> <p>Дээрхи зүйлийн талаар бүрэн ойлголтыг баталгаажуулахын тулд малчин айл өрхүүдэд өгөх бичгэн болон аман хэлбэрийн шууд мэдээлэл харилцаа. Эдгээр мэдээлэл харилцааг бүртгэнэ.</p>	орших 2 айл
<b>БАРИЛГЫН ҮЕ ШАТ</b>			
Барилгын үе шатны талаархи ерөнхий мэдээлэл өгөх	<p>Барилгын ажлын хуваарь  Барилгын үйл ажилагаа  Барилгын ажлын, явц  Барилгын нөлөө болон нөлөөг бууруулах арга хэмжээ</p>	<p>Олон нийтийн зарын самбар дээр зар тавих, дэлгүүр, орон нутгийн албан байгуулагууд дээр</p> <p>Товхимол, номоор болон нээлттэй цуглаанаар дамжуулан орон нутгийн бизнесийн бүлэг, оршин суугчдад хүргэх мэдээлэл, Олон нийтийн зарын самбар болон аюулгүйн тэмдэг</p> <p>Сонин: Өдрийн сонин, Зууны мэдээ</p> <p>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл: FM 101.5 Миний нутаг</p>	<p>ТББ  Орон нутгийн бүлэг  Олон нийтийн бүлгүүд  Нийт иргэд</p>

		Орон нутгийн харилцаа холбооны бүлгүүд, сар тутмын уулзалт	
Барилгын ерөнхий хуваарь			
		Барилгын ажлын хуваарь , ажлын цаг, талбайруу нэвтрэх замууд, аюулгүй ажиллагаа, мэдээлэл харилцаа болон гомдлын механизмын талаар тайлбарлах талаар төлөвлөсөн уулзалт	Усны шахах насосны станцын ойролцоох оршин суугчид
Шинэ авто замын ойролцоох Өргөн сумын хойд хэсгийн иргэдтэй хийх хэлэлцүүлэг	Оршин суугчидтай хийх шууд хэлэлцүүлэг. Санал хүсэлт, гомдол гарах тохиолдолд холбогдох хүний дэлгэрэнгүй хаяг, мэдээлэлийг багтаасан нэг хуудас зааварчилгаа	Барилгын ажлын хуваарь , ажлын цаг(өдрийн цагаар), талбайруу нэвтрэх замууд, аюулгүй ажиллагаа, мэдээлэл харилцаа болон гомдлын механизмын талаар тайлбарлах талаар төлөвлөсөн уулзалт	Шинэ замтай хамгийн ойр орших оршин суугчид (нэмэлт мэдээлэл дэх дуу чимээний судалгаанд тодорхойлсны дагуу)
Шинэ төмөр замын ойролцоох Өргөн сумын зүүн хэсгийн орон нутгийн иргэдтэй хийх тусгай хэлэлцүүлэг	Оршин суугчидтай шууд хэлэлцүүлэг хийн уулзах. Санал хүсэлт, гомдол гарах тохиолдолд холбогдох хүний дэлгэрэнгүй хаяг, мэдээлэлийг багтаасан нэг хуудас зааварчилгаа	Барилгын хуваарь, тооцоолсон төмөр замын хөдөлгөөн, дуу чимээний түвшин, ажлын цаг (өдрийн цаг), төмөр замын аюулгүй ажиллагаа, мэдээлэл харилцаа болон гомдлын механизмын талаар тайлбарлах тусгайлан төлөвлөсөн, биечлэн урьсан хэлэлцүүлгийн уулзалт	Шинэ төмөр замтай хамгийн ойр орших оршин суугчид (нэмэлт мэдээлэл дэх дуу чимээний судалгаанд тодорхойлсны дагуу)
Барилгын ажил дуусах, үйлдвэрлэл эхлэх	Үйлдвэр болон үйл үйлдвэрлэлийн тайлбар, Үйл ажиллагааны цагууд. Ажил эрхлэлтийн хэрэгцээ ба боломжууд	Хэвлэл нийтлэл “Сэнж Сант” ХХК-ийн вэб хуудсан дээр зарлах Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио, сонин	Засгийн газар, ТББ Орон нутгийн бүлэг Олон нийтийн бүлгүүд Боломжит ханган нийлүүлэгчид Боломжит үйлчлүүлэгчид Нийт иргэд

		Орон нутгийн харилцаа холбооны бүлгүүд, сар тутмын уулзалтууд.	
		Ил уурхайн үйл ажиллагаа, ажлын цаг, талбай руу нэвтрэх замууд, аюулгүй ажиллагаа, мэдээлэл харилцаа болон гомдлын механизмын талаар тайлбарлах хэлэлцүүлгийн төлөвлөсөн уулзалт	Усны насосны станцын ойролцоох оршин суугчид
<b>ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЕ ШАТ</b>			
Ажил эрхлэх боломжууд	Ажил эрхлэлтийн боломжууд, шаардагдах ур чадвар, сургалт болон дэмжлэг, мэдээлэлд нэвтрэх арга	Бүсийн, Сайншанд, Өргөн сумын ажил эрхлэх тухай хэвлэл нийтлэлд зарлах Сайншанд, Өргөн сумын олон нийт, төрийн байгууллагууд дээрхи мэдээллийн самбарууд  Сонин зар сурталчилгаа: Өдрийн сонин, Зууны мэдээ  Хэвлэл мэдээллийн хэрэгсэл: FM 101.5 Миний нутаг	Орон нутгийн ба бүсийн бүлэг  Орон нутгийн ба бүсийн бизнесийн хүмүүс
Усны нөөцөд малчид нэвтрэх боломж	газар доорхи усны нөөцийн ашиглалт, хэрэглээ ба гадаргуугийн усны онцлогт нөлөөлөх боломжит нөлөөний талаархи мэдээлэл, ялангуяа Шувуун Хөөвөр булаг	Талбайг ашиглаж байгаа малчидтай шууд уулзах, нэмэлт мэдээллийн тайлан доторхи (Газар доорхи усны нөөц) Усны бүлэгт тодорхойлсон үе шатууд: - хойд уст давхаргын дэлгэрэнгүй үнэлгээний үр дүн ба энэ уст давхаргатай холбоотой булаг, худагт нөлөөлөх	Хойд уст давхаргатай холбоотой усны нөөцийг сонирхож байгаа малчдын бүлэг, ялангуяа төслийн үйл ажиллагааны үе шатанд тодорхойлсон малчид

		<p>нөлөөллийн талаархи шинэчилсэн таамаглал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн ашиглах уст давхаргын боломжит ашиглалтын талаархи үнэлгээний үр дүн</li> <li>- ШувуунХөөвөр булгийн бүсэд гадаргуугийн усыг хиймлээр дахин бий болгох шаардлагын талаархи үнэлгээний үр дүн</li> </ul> <p>Усанд нэвтрэх боломжийг хязгаарлаагүй, хангамж муудаагүй байгаа гэдгийг баталгаажуулахын тулд бүсийн малчин бүлгүүдтэй 6 сар тутам уулзах. Эдгээр уулзалтуудын баримтжуулсан үр дүн, хэрвээ шаардлагатай бол, амласан үйл ажиллагааны төлөвлөгөө.</p>	
<p>Үйл ажиллагааны явц дахь Компанийн гүйцэтгэл</p>	<p>Байгаль орчин нийгмийн үнэлгээний төлөвлөгөөний талаархи жил бүрийн шинэчлэл ба тайлагнал</p>	<p>Компанийн тайлангууд</p> <p>Компанийн вэб хуудсын “Нийгмийн хариуцлага” хэсгийн товч хураангуй</p> <p>Гүйцэтгэлийг хянан магадлах, орон нутгийн оролцогч талуудын дэвшүүлсэн асуудлыг анхааран авч үзэх үүднээс томилогдсон бие бүрэлдэхүүнтэй жилд хоёр удаа уулзах(6 сар тутам)</p>	<p>Орон нутгийн оролцогч талууд Орон нутгийн бүлэг Ханган нийлүүлэгчид үйлчлүүлэгчид</p>

---

		Орон нутгийн харилцаа холбооны бүлгүүд, зургаан сар тутмын уулзалтууд	Орон нутгийн бүлгүүд Олон нийтийн бүлгүүд
--	--	-----------------------------------------------------------------------------	----------------------------------------------

---

### **6.3 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ, ГОМДОЛ САНАЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ**

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зар мэдээний мэдэгдэл, судалгаа, үзэсгэлэн, нүүр тулан уулзах уулзалтууд болон тогтмол уулзалтууд гэх зэрэг мэдээлэл харилцааны сувгуудаар дамжуулан, “Сэнж Сант” ХХК нь зохих ёсоор хяналт тавин, хариу санал бодлыг ханган өгнө.

Цаашдын чухал хэлэлцүүлэг, зөвлөгөөн, уулзалт, олон нийтийн үзэсгэлэнгүүдэд оролцогч талуудыг бүрэн хамруулах үүднээс харьяа газруудад зохион байгуулна. Олон нийтийн санал хүсэлтийг бүртгэх үүднээс зохих газарт нээлттэй дэвтэр (үзэгтэй) байрлуулна. Үзэсгэлэнгийн тодорхой нэг хэсэгт энэхүү дэвтэр нь олон нийтийн хүртээл болох боловч тухайн үзэсгэлэнг зохион байгуулж буй хүмүүсийн шууд хяналтанд **байхгүй**. Оролцогч талуудад хариулт болон хариу санал бодлыг хүргэх үүднээс мэдээллийг “Сэнж Сант” ХХК бүртгэн авах болно.

Жил бүр “Сэнж Сант” ХХК Байгаль орчин, нийгмийн үнэлгээний төлөвлөгөөний техникийн бус тодорхойлолтыг багтаасан гүйцэтгэлийн тайлан боловсруулах ба олон нийттэй хэлэлцсэн асуудлын талаархи мэдээллийг бэлдэнэ.

### **6.4 ГОМДОЛ САНАЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ**

“Сэнж Сант” ХХК нь санал хүсэлт болон гомдолд хариу өгөх менежементэд албан ёсны арга хэмжээг хэрэгжүүлнэ. Энэ нь оролцогч талуудын санал гомдлыг ойлгох, тэдгээрт хариулт өгөх, асуудлуудыг үр нөлөөтэй шийдвэрлэхэд маш чухал байдаг. Гомдлын механизмыг доорхи зураг 1-д танилцуулсны адил гаргах болно. Дор үзүүлсэн гомдол санал гаргах маягтыг хэрэглэх болно.

Энэхүү баримт бичиг болон төслийн үүрэг амлалтын талаархи аливаа тайлбар, шүүмжлэл, бусад санал хүсэлтийг хүлээн авна. Түүнчлэн, бид төсөлтэй холбоотой аливаа гомдлын менежементэд нээлттэй, ил тод, албан ёсны арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Аливаа гомдлыг зохицуулан шийдвэрлэх үйл явцын ерөнхий тоймыг доор багтаав.

- Та манай оффис дээр бичгээр, и-мэйлээр, биечлэн аливаа санал гомдол, эсвэл бусад тайлбар, шүүмжлэлийг тайлагнавал бид хүлээж авна.
- Бид асуудлуудыг нарийвчлан авч хэлэлцэх бөгөөд албан ёсны үнэлгээг эхлүүлэх үүднээс манай олон нийттэй харилцах алба бүрэн мэдээллээр хангагдсан байна. Бид стандарт маягтын дагуу гомдлын талаархи огноо, холбоо барих мэдээллийг бүртгэн авч, төслийн гомдлын бүртгэл дээр нэг хуулбарыг байрлуулна.
- Таны дэвшүүлсэн санаа зовниж байгаа асуудлыг тайлагнахад хэрэглэх маягтыг авах боломжтой. Энэ маягтыг бөглөснөөр бид өөрсдийн хяналт шалгалтыг үр


---

нөлөөтэй явуулахад шаардагдах бүх мэдээллийг олж авах юм. Шаардлагатай бол та энэхүү маягтыг нэрээ нууцлан бөглөх боломжтой.

- Уг асуудлын хариултанд юуг хүсч байгаа тухай таны саналыг бид хүлээн авна.
- Манай хяналт шалгалтын нэг хэсэг болох засан залруулах, урьдчилан сэргийлэх ажиллагаа болон цаашдын хяналт шалгалтанд юу чухал вэ гэдгийг үнэлэх судалгаа явуулна.
- Бид танд 30 хоногийн дотор хариу мэдээлэх бөгөөд гомдлын бүртгэл дотор бидний хийж гүйцэтгэсэн засан залруулах, урьдчилан сэргийлэх ажиллагааны талаархи дэлгэрэнгүйг байрлуулах болно. Хэрвээ шаардлага хангасан шийдэлд хүрэхэд илүү урт хугацааны хөтөлбөр шаардагдвал гомдлыг хүлээн авах тусгай бүртгэлийг хөтөлнө.

Ер нь бичгэн эсвэл аман байдлаар хүлээн авсан бүх гомдлыг бүртгэнэ. Гомдол гаргасан этгээд нь гомдлыг хүлээн авсан талаархи бичгийг хүлээн авна.

**График 1: Гомдол саналыг боловсруулах бүдүүвч**





**Олон нийтийн гомдол барагдуулах маягт**

<b>Дугаар:</b>	
<b>Овог нэр:</b>	
<b>Холбоо барих хаяг:</b>  <b>Таньтай хэрхэн холбоо барих вэ? (и-мэйлээр, утсаар).</b>	<input type="checkbox"/> <b>Шуудангаар:</b> Шуудангийн хаягаа бичнэ үү: _____ _____ _____ <input type="checkbox"/> <b>Утсаар:</b> _____ <input type="checkbox"/> <b>И-мэйлээр</b> _____
<b>Холбоо барихад ямар хэлээр харилцах вэ?</b>	<input type="checkbox"/> [Англи] <input type="checkbox"/> [Монгол]
<b>Гомдлын тодорхойлолт:</b>	Юу болсон? Хаана болсон? Хэнээс болсон? Асуудлын үр дүн юу вэ?
<b>Болсон үйл явдлын огноо</b>	
	<input type="checkbox"/> <b>Нэг л удаа болсон (огноо _____)</b> <input type="checkbox"/> <b>Нэгээс илүү болсон (хэдэн удаа _____)</b> <input type="checkbox"/> <b>Одоо болж байгаа (энэ цаг мөчид үргэлжилж байгаа)</b>
<b>Энэ асуудлыг хэрхэн зохицуулаасай гэж та хүсэж байна вэ?</b>	

Гарын үсэг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

---

**Энэ маягтыг дараах хаягаар явуулах:**

**Цэрэнпилийн Халиун**

**Төслийн туслах**

**Мэйл хаяг: [khaliun@monpolymet.mn](mailto:khaliun@monpolymet.mn)**

**Утас: 99220792**

